



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 05 дугаар сарын 14  
№20 (1365)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |     |                                                                              |           |     |
|-----|------------------------------------------------------------------------------|-----------|-----|
| 88. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай | Дугаар 38 | 898 |
|-----|------------------------------------------------------------------------------|-----------|-----|

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

- |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                        |     |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|-----|
| 89. | Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албаны дарга буюу ахлах прокурор, хяналтын прокурор болон Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажил хариуцсан хяналтын прокурорын нэхэмжлэлтэй, нийслэлийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийн тухай | Дугаар 001/ХТ2024/0099 | 901 |
| 90. | Г.Сонинболорын нэхэмжлэлтэй, Шүүхийн ерөнхий зөвлөлд холбогдох захиргааны хэргийн тухай                                                                                                                                                                                                                                                                                        | Дугаар 001/ХТ2024/0103 | 913 |
| 91. | Прокурор Н.Эрдэмбилэгийн дүгнэлтээр, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах байцаагчид холбогдох захиргааны хэргийн тухай                                                                                                                                                                                                                                    | Дугаар 001/ХТ2024/0109 | 919 |
| 92. | “Ондо” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Харилцаа холбооны зохицуулах хороонд холбогдох захиргааны хэргийн тухай                                                                                                                                                                                                                                                                           | Дугаар 001/ХТ2024/0117 | 925 |



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

### **Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1.2.2</sup> дахь заалт, 14<sup>1.3</sup> дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сүхбаатарын Эрдэнэбатыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Баяраагийн Рагчааг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилсугай.

3.Энэ тогтоолыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

Хүснэгт 3

2025 он, 1-12 сарын 31-ийн үеийн

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

Бүс нутаг, төр, засаг, байгууллага, иргэд, хуульчид

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 001/ХТ2024/0099

Улаанбаатар  
хот

**Улсын ерөнхий прокурорын газрын  
Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн Төр,  
нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албаны дарга  
буюу ахлах прокурор, хяналтын прокурор болон  
Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг  
төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг  
хамгаалах ажил хариуцсан хяналтын прокурорын  
нэхэмжлэлтэй, нийслэлийн Засаг даргад  
холбогдох захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн  
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

|                       |                      |
|-----------------------|----------------------|
| Даргалагч, шүүгч      | Д.Батбаатар          |
| Танхимын тэргүүн:     | Д.Мөнхтуяа           |
| Шүүгчид:              | Х.Батсүрэн<br>Ц.Цогт |
| Илтгэгч шүүгч:        | М.Батсуурь           |
| Нарийн бичгийн дарга: | Б.Зэнээмэдрээ        |

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны  
04 дүгээр сарын 04-ний өдрийн 128/ШШ2024/0305 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 06  
дугаар сарын 06-ны өдрийн 221/МА2024/0371 дүгээр магадлал,

Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны  
2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 001/ШХТ2024/0293 дугаар  
хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, нэхэмжлэгч хяналтын прокурор  
Ш.Сувд-Эрдэнэ, гуравдагч этгээд “Баянтуяарах од” ХХК-ийн итгэмжлэгдсэн  
төлөөлөгч С.Оджаргал, өмгөөлөгч Х.Цэрэндолгор, гуравдагч этгээд  
А.Бямбасүрэнгийн өмгөөлөгч Б.Батбаяр нарыг оролцуулан нэхэмжлэгч  
Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн төр  
нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажил хариуцсан хяналтын прокурорын  
хяналтын журмаар гаргасан гомдлоор хянан хэлэлцэв.



## ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага: “Нийслэлийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/955 дугаар захирамжийн А.Бямбасүрэнд холбогдох хэсэг, нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/1279 дүгээр захирамжийн “Баянтуяарах од” ХХК-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгуулах”

2.Хэргийн нөхцөл байдал: Иргэн А.Бямбасүрэн нь нийслэлийн Засаг даргын 2018 оны А/955 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд 1094 м.кв газрыг үйлчилгээ, конторын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшсэн бөгөөд 2019 онд “Баянтуяарах од” ХХК-тай газрын эрх шилжүүлэх гэрээ байгуулсан, улмаар тус компанийн Газар зохион байгуулалтын албанд гаргасан хүсэлтэд үндэслэн нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1279 дүгээр захирамжаар А.Бямбасүрэнгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг “Баянтуяарах од” ХХК-д шилжүүлсэн байна.

2.1.Монгол Улсын Засгийн газраас “... Нийслэл Улаанбаатар хотод үргэлжлэн орсон борооны улмаас үер усны аюултай нөхцөлийг бүрдүүлж, усны сан бүхий газарт тогтоосон хамгаалалтын бүсийг зөрчиж газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгосон, үер усны далан шуудууг сэтлэн барилга, байгууламж барьсан этгээдүүдээс төр, олон нийтэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах...” агуулга бүхий 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн ЗГ-1/115 дугаар албан бичгийг Монгол Улсын ерөнхий прокурорт хүргүүлсэн, тус албан бичгийн дагуу Улсын ерөнхий прокурорын 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/86 дугаар тушаалаар ... Нийслэл Улаанбаатар хотод үүссэн үер, усны аюултай нөхцөл байдлын улмаас бий болсон хор уршиг, шалтгаан нөхцөл, эрх бүхий албан тушаалтан, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, шийдвэрийн хууль зүйн үндэслэлд дүгнэлт хийж, төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулжээ.

2.2.Нэхэмжлэгч нараас нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ “... Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу нотлох баримт цуглуулах ажиллагаа явуулж, төрийн байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл, судалгаа, холбогдох баримтыг гаргуулан авч, танилцахад эрх бүхий албан тушаалтнаас хууль тогтоомж зөрчин Сэлбэ, Дунд голын үерийн далангийн хамгаалалтын бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгосон, тухайн газарт барилга, байгууламж бариагүй нөхцөл байдал тогтоогдсон. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/955 дугаар захирамжаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших эрх олгохдоо Усны тухай, Газрын тухай хууль, Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг зөрчиж,

иргэн А.Бямбасүрэнд газар эзэмших эрх олгосон, 2019 оны А/1279 дүгээр захирамжаар А.Бямбасүрэнгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг “Баянтуяарах од” ХХК-д шилжүүлсэн нь хууль тогтоомжоор хориглосон, хууль бус, нийтийн ашиг сонирхол зөрчсөн үйлдэл болсон, Монгол Улсын Ерөнхий сайдаас прокурорын байгууллагад ирүүлсэн хүсэлтийг судлах, шийдвэрлэх явцад хүсэлтэд дурдагдаагүй, эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжоор тогтоосон онцгой хамгаалалтын бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар эзэмших эрх олгох шийдвэр гаргаснаар үерийн далан, суваг таглан барилга, байгууламж баригдах, олон нийтэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үүднээс өөрийн санаачилгаар нэхэмжлэл гаргах шаардлагатай гэж дүгнэсэн ...” гэж тодорхойлон “... гуравдагч этгээд тухайн газрыг үйлчилгээ, конторын зориулалтаар авсан, гэтэл тус газарт нийслэлчүүдийн ундны эх үүсвэр байрладаг, мөн бүхэлдээ усан сан бүхий, усны хамгаалалт, онцгой хамгаалалттай болон үерийн далангийн хамгаалалтын бүсэд орсон, прокурорын гаргасан нэхэмжлэл нь нийтийн эрх ашгийг хамгаалах зорилготой, эрх бүхий этгээдээс үер усны ам бүхий газарт газар олгож байгаа асуудал нь үндэсний аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэндийн байдалтай холбоотой байна гэж үзсэн ...” гэж маргасан.

2.3.Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс “... маргаан бүхий газар нь холбогдох хууль тогтоомж, сайдын тушаалд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчиж олгогдсон, усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс, үерийн далангийн хамгаалалтын бүс, цахилгаан станцын хамгаалалтын бүсэд орсон байх тул нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч байна, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд татгалзах зүйлгүй, ... Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.10-т заасан үндэслэл хэрвээ тогтоогдох юм бол маргахгүй, хэрвээ тогтоогдохгүй бол маргана ...” гэж;

2.4.Гуравдагч этгээд А.Бямбасүрэнгээс “... нийслэлийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Газар эзэмших, ашиглах эрх олгох тухай” А/955 дугаар захирамжаар холбогдох журмын дагуу Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд 1094 м.кв газрыг эзэмших болсон. Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан боловч санхүүжилтгүйн улмаас 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр “Баянтуяарах од” ХХК-д хуульд заасан журмын дагуу эзэмших эрхээ шилжүүлсэн. Миний хувьд тухайн үеийн мөрдөгдөж байсан журам дүрмийн дагуу хүсэлт гаргаж, газраа эзэмшиж, эзэмших эрхээ шилжүүлсэн ...” гэж;

2.5.Гуравдагч этгээд “Баянтуяарах од” ХХК-аас “... 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр иргэн А.Бямбасүрэнтэй газар худалдах, худалдан авах гэрээ байгуулсны үндсэн дээр маргаан бүхий газрыг худалдан авч, хуульд заасан үндэслэл журмын дагуу нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/1279 дугаар захирамжаар эзэмшиж байгаа. Хэрэв маргаан бүхий газар нь нэхэмжлэлийн шаардлагад





дурдсанчлан тусгай хамгаалалтад хамаарах газар байсан бол анхнаасаа газар эзэмших эрхийн гэрчилгээг хариуцагчийн зүгээс хувь хүн, хуулийн этгээдэд хууль зөрчиж олгохгүй байсан. Тухайн үед хариуцагч газар эзэмших, ашиглах эрхийг олгохтой холбоотойгоор холбогдох хууль тогтоомж, журамд заасан судалгааг хийсний үндсэн дээр тус газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх бүрэн боломжтой гэж үзэж, хуульд заасны дагуу олгосон байдаг. Гэтэл 2, 3 жилийн дараа хууль зөрчсөн гэж байгаа нь гуравдагч этгээдийн хууль ёсны эрх ашгийг, Үндсэн хуульд заасан шударгаар эд хөрөнгийг өмчлөх, эзэмших эрхийг ноцтойгоор зөрчиж байна, мөн компаниас төлбөр мөнгө, санхүү эд хөрөнгө, цаг хугацаа олон зүйлээр хохирох эрсдэлтэй байна ..." гэж тус тус тайлбар гаргажээ.

3.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4, 33 дугаар зүйлийн 33.6-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэхдээ "... Нэхэмжлэгч прокурорууд нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд нийтийн эрх, ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан, ... усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүстэй давхацсан газрыг иргэн А.Бямбасүрэнд эзэмшүүлж, улмаар уг газар эзэмших эрхийг "Баянтуяарах од" ХХК-д шилжүүлж шийдвэрлэсэн хариуцагчийн шийдвэр нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д заасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн, нийслэлийн Засаг даргын уг хууль бус шийдвэрүүдийн улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй нь тогтоогогдож байх тул эдгээр захирамжуудыг хүчингүй болгох нь зүйтэй ..." гэж дүгнэжээ.

4.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх гуравдагч этгээдийн өмгөөлөгчийн гомдлоор хэргийг хянаад "... захиргааны байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөхөөр нэхэмжлэл гаргаж маргах нь Үндсэн хуульд заасан агуулга буюу прокурорын байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үндсэн чиг үүрэг болон Захиргааны хэргийн шүүхийн "захиргааны хууль бус шийдвэрээс иргэдийг хамгаалах" үндсэн зорилготой нийцэхгүй байна, ... прокурор өөрийн санаачилгаар эсхүл аль нэг төрийн байгууллага, албан тушаалтны хүсэлтээр захиргааны өөр нэг байгууллагын шийдвэр үйл ажиллагааг хүчингүй болгуулахаар гаргасан нэхэмжлэл /захиргааны байгууллага хоорондын маргаан/ -ийг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, захиргааны хэргийн шүүхийн үндсэн зорилгод нийцэхээргүй байна, ... Хэдийгээр прокурорын байгууллагын өөр нэг төрийн байгууллагын бусдад эрх олгосон эрхийг хязгаарласан зэрэг аливаа шийдвэрийг хүчингүй болгуулах гэх мэт хэлбэрээр гарч буй нэхэмжлэлтэй хэрэгт эрх нь хөндөгдсөн эсхүл хөндөгдөж болзошгүй гуравдагч этгээд оролцох боломжтой хэдий ч төрийн захиргааны нэг байгууллага нь хүсэлт гаргаснаар прокурорын

байгууллагаас өөр нэг төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг өөрчлүүлэхээр нэхэмжлэл гаргах, уг нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх нь Үндсэн хуульд заасан прокурорын үндсэн чиг үүрэгтэй нийцэхгүй байна ....” гэсэн үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

5.Нэхэмжлэгч нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажил хариуцсан хяналтын прокурорын хяналтын журмаар гаргасан гомдлыг 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Улсын дээд шүүх хүлээн авч, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 001/ШХТ2024/0293 дугаар тогтоолоор “хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн”, “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” эсэх үндэслэлүүдээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 6.Хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл:

6.1.“... Давж заалдах шатны шүүхээс Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1-д заасан зохицуулалтад заасан прокурорын “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” чиг үүрэг нь түүний хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих буюу аливаа гэмт хэрэг зөрчлийг бүртгэж, хянах чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хэрэгжих агуулгаар томъёологдсон, түүнчлэн захиргааны байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөхөөр нэхэмжлэл гаргаж маргах нь Үндсэн хуульд заасан агуулга захиргааны хэргийн шүүхийн “захиргааны хууль бус шийдвэрээс иргэдийг хамгаалах” үндсэн зорилготой нийцэхгүй, мөн захиргааны байгууллага хоорондын маргааныг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, захиргааны шүүхийн үндсэн зорилгод нийцэхээргүй байна гэж дүгнэн шийдвэрлэсэн нь ойлгомжгүйгээс гадна прокурорын нэхэмжлэлийн зорилго, агуулгыг ойлгоогүй хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж дүгнэхээр байна.

6.2.Учир нь Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэх хуулийн зохицуулалт нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1-д заасан зохицуулалтад заасан прокурорын “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” хуулийн зохицуулалттай уялдаатай буюу прокурор төрийн болон нийтийн ашиг



сонирхлыг төлөөлөн эрүү, иргэн, захиргааны хэргийн бүх шүүх хуралдаанд оролцох эрхтэй байна. Ингэж оролцохдоо төрийн болон нийтийн ашиг сонирхлыг урьтал болгох нийтийн зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй эрх ашиг сонирхлыг хамгаалах нь прокурорын хуульд заасан бүрэн эрх юм.

6.3.Гэтэл давж заалдах шатны шүүх хуулийн дээрх зохицуулалтыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих буюу аливаа гэмт хэрэг зөрчлийг бүртгэж, хянах чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хэрэгжих агуулга буюу явцуу хүрээгээр хязгаарлаж тайлбарлаж байгаа нь Үндсэн хууль болон Прокурорын тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтуудыг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэх үндэслэлд хамаарч байна.

6.4.Прокурорын нэхэмжлэл нь гуравдагч этгээдийн эрх ашиг сонирхлыг хөндөж байгаа агуулгатай гэж шүүхээс тайлбарлаж байгаа хэдий боловч нэхэмжлэл нь нийт ард иргэдийн зөрчигдөж буй, зөрчигдөж болзошгүй язгуур эрх буюу Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага буюу захирамжилсан шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох агуулгаар бичигдсэн болно.

6.5.Прокурорын нэхэмжлэлд Нийслэлийн Засаг даргын захирамж нь Усны тухай хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн “Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээх” зорилго, зорилтыг зөрчсөнөөс гадна Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг зөрчсөн нь Улаанбаатар хотын ард иргэдийн цэвэр усны эх үүсвэртэй шууд холбоотой, эрүүл мэндийн асуудал хөндөгдөж байгааг илэрхийлсэн төдийгүй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан “... хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна ...” гэсэн зорилттой нийцсэн байхад шүүх дээрх зохицуулалтыг буруугаар тайлбарлаж, үндэслэлгүй шийдвэр гаргасан гэж дүгнэж байна.

6.6.Иймд давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь Улсын дээд шүүхийн тайлбараас өөрөөр хэрэглэсэн, шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах зорилгоор магадлалыг хүчингүй болгуулахаар гомдол гаргасан ...” гэжээ.

7.Нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдолтой холбогдуулан хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс шүүхэд тайлбар ирүүлээгүй, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нар шүүх хуралдаанд тайлбараа гаргасан.

#### ХЯНАВАЛ:

8.Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон нь зөв боловч зарим дүгнэлт буруу байх тул дараах үндэслэлээр уг дүгнэлтийг өөрчилж, шийдлийг хэвээр үлдээв.

9.Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай” 30 дугаар тогтоолын Тайлбарын дэлгэрэнгүй үндэслэл хэсэгт “... Хуулийн дээрх зохицуулалтын дагуу нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь прокурорын үйл ажиллагааны үндсэн зарчим ба энэ хүрээнд нэгд, төрийн байгууллагын хүсэлтээр, хоёрт, өөрийн санаачилгаар захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд үндсэн нэхэмжлэгч, эсхүл, гуравдагч этгээдээр оролцох боломжтой; ингэхдээ итгэмжлэлгүйгээр оролцох эрхийг хууль тогтоогч тодорхой хуульчилжээ ...”<sup>1</sup> гээд Тайлбарлах нь хэсгийн б/-д “Прокурор өөрийн санаачилгаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор захиргааны хэргийн шүүхэд хандаж нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд итгэмжлэлгүйгээр, харин төрийн байгууллагын хүсэлтээр нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд итгэмжлэлийн үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно”, мөн хэсгийн г/-д “тусгайлан” гэх нөхцөлд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн ямар этгээд, ямар хүрээнд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг тусгайлан зааж баталгаажуулсан байхыг ойлгоно. Харин хуульд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах хүрээнээс өөрөөр заагаагүй бол дурдсан дөрвөн үндсэн хүрээнд хамаарах асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзнэ”<sup>2</sup> хэмээн тайлбарлажээ.

10.Гэтэл давж заалдах шатны шүүх “... Прокурорын тухай хуульд төрийн болон нийтийн эрх ашгийг төлөөлөн эрүү, иргэн, захиргааны хэргийн бүх шүүх хуралдаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд хэн алианаар оролцох эрхтэй байдлаар хуульчилсан байх боловч захиргааны байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөхөөр нэхэмжлэл гаргаж маргах нь Үндсэн хуульд заасан агуулга буюу прокурорын байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үндсэн чиг үүрэг ... нийцэхгүй ...” гэж дүгнэсэн нь дээрх тайлбарын агуулгад нийцэхгүй.

<sup>1</sup> Хууль хэрэглээний нэгдмэл байдал: Улсын дээд шүүхийн тайлбарын эмхэтгэл, УБ., 2024, 181 дэх тал

<sup>2</sup> Мөн эмхэтгэл, 202 дахь тал



11.Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч Прокурорын тухай хуулиар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг заасан байхад тухайн шүүх (шүүх бүрэлдэхүүн)-ээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т зааснаар Улсын дээд шүүхэд санал гаргаагүй атлаа Үндсэн хуулийг зөрчсөн дүгнэлт хийж, “Үндсэн хуульд заасан прокурорын чиг үүрэгтэй нийцэхгүй” гэх агуулгаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь буруу болжээ.

12.Харин давж заалдах шатны шүүхийн “... прокурорын өөрийн санаачилгаар эсхүл аль нэг төрийн байгууллага, албан тушаалтны хүсэлтээр захиргааны өөр нэг байгууллагын шийдвэр үйл ажиллагааг хүчингүй болгуулахаар гаргасан нэхэмжлэл (захиргааны байгууллага хоорондын маргаан)-ийг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, захиргааны хэргийн шүүхийн үндсэн зорилгод нийцэхээргүй ...” гэх дүгнэлт энэ тохиолдолд зөв байна.

13.Учир нь, нэхэмжлэгч прокурор нар нь нийслэлийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Газар эзэмших, ашиглах эрх олгох тухай” А/955 дугаар захирамжийн хавсралт 65-д заасан Хув овогт Аюурзанын Бямбасүрэнд холбогдох хэсэг, нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/1279 дугаар захирамжийн “Баян туяарах од” ХХК-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гаргаж, үндэслэлээ “... Монгол Улсын Ерөнхий сайд 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн ЗГ- 1/115 дугаартай албан бичгээр, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Прокурорын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасныг үндэслэн “Нийслэл Улаанбаатар хотод үргэлжлэн орсон борооны улмаас үер усны аюултай нөхцөлийг бүрдүүлж, усны сан бүхий газарт тогтоосон хамгаалалтын бүсийг зөрчиж газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгосон, үер усны далан шуудууг сэтлэн барилга, байгууламж барьсан этгээдүүдээс төр, олон нийтэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах” агуулга бүхий хүсэлтийг прокурорын байгууллагад ирүүлсэн ... Гэтэл нийслэлийн Засаг дарга 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/955 дугаартай захирамжаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших эрх олгохдоо Усны тухай, Газрын тухай хууль болон “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам” зөрчиж /газар эзэмшүүлж, шилжүүлсэн/...” гэж тайлбарлажээ.

14.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх

бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 3 дугаар зүйлийн 3.1.3-т “нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг,” гэж тус тус зааснаар захиргааны хэргийн шүүхийн нэн тэргүүний зорилго нь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол (субъектив эрх)-ыг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас хамгаалж, зөрчигдсөн тохиолдолд уг эрхийг сэргээн эдлүүлэхэд оршино.

15.Харин тодорхой чиглэсэн хүн, хуулийн этгээд байхгүйн улмаас субъектив эрхийн хүрээнд шүүхэд хандаж маргах боломжгүй, уг чиглэсэн үйл ажиллагааны улмаас хариуцсан захиргааны байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн (объектив эрхийн) гэж үзвэл уг асуудлаар тодорхой этгээдэд шүүхэд хандаж нэхэмжлэл гаргах эрхийг хууль тогтоогч ялгамжтай тогтоож, хязгаартай нээсэн бөгөөд энэ нь “... хэмжээ, хязгааргүй, эцэс, төгсгөлгүй нэхэмжлэлд шүүх дарагдахгүй, захиргааны шийдвэр бас эцэс, төгсгөлгүй нэхэмжлэлд уягдахгүй ...”<sup>3</sup> байх хууль тогтоогчийн үзэл баримтлалаас үүдэлтэй. Тодруулбал, төр, захиргааны байгууллага хоорондын хууль зөрчсөн эсэх маргаан шийдвэрлэх нь захиргааны шүүхийн нэн тэргүүний зорилт биш юм.

16.Мөн Прокурорын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Прокурор хуульд заасан тохиолдолд дараахь шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно:” гээд 17.1.3-т “захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх” гэж, 20 дугаар зүйлийн 20.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэж тус тус зааснаар прокурор нь хуульд заасан тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй буюу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу оролцох боломжтой байна.

17.Маргаанд хамаарах хууль тогтоомжийг авч үзвэл, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны тэмдэглэл



ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хяналт тавих асуудлаар хэн ямар чиг үүрэг, бүрэн эрхтэй талаар тодорхой хуульчилжээ.

18.Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 1/-д “байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;”, 2/-т “байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах;” гэж, 16 дугаар зүйлийн 2-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 1/-д “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;” гэж, 4/-т “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;” гэж, 26 дугаар зүйлийн 1-д “Улсын байцаагч дараахь эрхтэй байна:” гээд 1/-д “иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;”, 11/-д “байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх” гэж;

19.Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 11.1.1-д “усны тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;” гэж, 12.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 12.1.4-т “усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, хамгаалах, тохижуулах, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах;” гэж, 13 дугаар зүйлийн 13.1-д “Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 12.1.1, 12.1.3-т зааснаас гадна усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 13.1.6-д “усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын,

эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийг мөрдүүлэх;” гэж, 18 дугаар зүйлийн 18.1-д “Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд 18.1.1-д “усны тухай хууль тогтоомжийн биелэлтийн явцад хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;” гэж, 20 дугаар зүйлийн 20.4-т “Сав газрын зөвлөл нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд 20.4.6-д “усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн мөрдөлтөд хяналт тавих;” гэж тус тус заасан байна.

20.Тодруулбал, дээр дурдсанчлан усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хяналт тавих асуудлыг хэд хэдэн захиргааны байгууллага, албан тушаалтан хуулиар өөрт олгогдсон чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд хариуцаж ажиллах үүрэгтэй байна.

21.Дурдсан хуулийн зохицуулалтыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын тухай хуультай харилцан уялдаанд нь авч үзвэл, усны хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэд хэдэн захиргааны байгууллага, албан тушаалтанд хуулиар хариуцуулсан бөгөөд тухайн этгээд өөр захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас уг чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн гэж үзвэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэл гаргах, энэ хүрээнд прокурорын байгууллагад хүсэлт тавьж, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцуулах боломжтой байна.

22.Ийнхүү захиргааны байгууллага, албан тушаалтнаас уг асуудлаар шүүхэд хандаж нэхэмжлэл гаргаагүй, төлөөлүүлэхээр хүсэлт гаргаагүй байхад прокурорын зүгээс “өөрийн санаачилгаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа” гэх үндэслэлээр буюу хуулиар өөр захиргааны байгууллага, албан тушаалтанд хариуцуулсан асуудлаар гаргасан нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх хүлээн авч шийдвэрлэх нь хуулийн үндэслэлгүй, “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” гэж үзэхээр байх тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан давж заалдах шатны шүүхийн шийдэл зөв; нэхэмжлэгч прокурорын “... Прокурорын тухай хуулийн ... зохицуулалт нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1-д заасан зохицуулалтад заасан прокурорын “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” хуулийн зохицуулалттай уялдаатай буюу прокурор төрийн болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн эрүү, иргэн, захиргааны хэргийн бүх шүүх хуралдаанд оролцох эрхтэй байна. Ингэж оролцохдоо төрийн болон нийтийн ашиг сонирхлыг урьтал болгох нийтийн зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй эрх ашиг сонирхлыг хамгаалах нь прокурорын хуульд заасан бүрэн эрх ...” гэх агуулгаар гаргасан гомдлыг хангах боломжгүй.





23.Нөгөө талаас, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно” гэж зааснаар аймаг, нийслэлийн Засаг дарга хууль зөрчиж газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан гэж үзвэл өөрөө, эсхүл дээд шатны албан тушаалтан болох Ерөнхий сайд өөрийн эрх хэмжээний хүрээнд уг шийдвэрийг хүчингүй болгох боломжтой байгааг дурдах нь зүйтэй.

24.Дээр дурдсан үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгч хяналтын прокурорын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.1-д заасныг баримтлан ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 221/МА2024/0371 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгч Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажил хариуцсан хяналтын прокурор Ш.Сувд-Эрдэнийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар нэхэмжлэгч тэмдэгтийн хураамж төлөөгүйг дурдсугай.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ**

**Д.БАТБААТАР**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.МӨНХТУЯА**

**ШҮҮГЧИД**

**Х.БАТСҮРЭН**

**Ц.ЦОГТ**

**М.БАТСУУРЬ**

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН  
ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 10 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 001/ХТ2024/0103

Улаанбаатар  
хот

**Г.Сонинболорын нэхэмжлэлтэй,  
Шүүхийн ерөнхий зөвлөлд холбогдох  
захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн  
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

|                       |               |
|-----------------------|---------------|
| Даргалагч, шүүгч:     | Х.Батсүрэн    |
| Танхимын тэргүүн:     | Д.Мөнхтуяа    |
| Шүүгчид:              | М.Батсуурь    |
|                       | П.Соёл-Эрдэнэ |
| Илтгэгч шүүгч:        | Ц.Цогт        |
| Нарийн бичгийн дарга: | Б.Зэнээмэдрээ |

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны  
06 дугаар сарын 18-ны өдрийн 128/ШШ2024/0527 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 07  
дугаар сарын 30-ны өдрийн 221/МА2024/0497 дугаар магадлалтай,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2024 оны 10  
дугаар сарын 08-ны өдрийн 334 дүгээр хэлэлцүүлэх тогтоолтой захиргааны  
хэргийг нэхэмжлэгч Г.Сонинболор, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч  
О.Должиндэмид нарыг оролцуулан, хариуцагчийн итгэмжлэгдсэн  
төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг үндэслэн хянан  
хэлэлцэв.

**ТОДОРХОЙЛОХ нь:**

Нэхэмжлэлийн шаардлага:

1.Нэхэмжлэгч Г.Сонинболороос Шүүхийн ерөнхий зөвлөлд  
холбогдуулан “Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гаргахад олгох нэг



удаагийн тэтгэмжийн зөрүү 21,929,373 төгрөгийг гаргуулах” нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Хэргийн нөхцөл байдал:

2.Нэхэмжлэгч Г.Сонинболор нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 69 дүгээр зарлигаар шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9-д заасан шүүгчийн өндөр насны тэтгэврийн нэг удаагийн тэтгэмж болох 100,800,000 төгрөгийг нэхэмжлэгчид шилжүүлсэн байна.

2.1.Өмнө нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 128/ШШ2024/0041 дүгээр шийдвэрээр нэхэмжлэгч Г.Сонинболорын нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зөрүүг олгохгүй байгаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, тэтгэмжийн зөрүү 38,550,627 төгрөгийг гаргаж нэхэмжлэгчид олгохыг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгаж шийдвэрлэсэн байна.

2.2.Энэхүү шийдвэрийг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлоор хянаад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 221/МА2024/150 дугаар магадлалаар нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 128/ШШ2024/0041 дүгээр шийдвэрт өөрчлөлт оруулж, нэхэмжлэгчид дутуу олгосон тэтгэмжийг зохих журмын дагуу тооцож олгохыг хариуцагч Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгасан байна.

3.Нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ “... миний бие хуульд заасны дагуу төрөөс авах ёстой нэг удаагийн мөнгөн тэтгэмжээ бүрэн авч чадахгүй Шүүхийн ерөнхий зөвлөлийн эс үйлдэхүйн улмаас хохирч байна. ... Нэг удаагийн тэтгэмжийн зөрүү олгохгүй байгаа хариуцагч Шүүхийн ерөнхий зөвлөлийн эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож шийдвэрлэсэн байхад тэтгэмжийн зөрүү олгохгүй өндөр настан намайг хохироож байна” гэжээ.

4.Хариуцагчаас “... шийдвэрийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэхэмжлэгч Г.Сонинболорын данс руу 38,550,627 төгрөгийг шилжүүлэн олгосон” гэж маргаж байна.

Анхан шатны шүүхийн шийдвэр:

5.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 128/ШШ2024/0527 дугаар шийдвэрээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46.2, 47.9, Хөдөлмөрийн тухай хуулийн 101.1, 103.1.1-д заасныг баримтлан нэхэмжлэгч Г.Сонинболорын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зөрүү олгохгүй байгаа эс үйлдэхүйг хууль бусад тооцож, 21,929,373 төгрөгийг олгохыг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгажээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

6.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 221/МА2024/0497 дугаар магадлалаар нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 128/ШШ2024/0527 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын давж заалдах гомдлыг хангахгүй орхисон байна.

Хяналтын журмаар гаргасан гомдол:

7.Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Чулуунчимэгээс шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргажээ.

7.1.Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 001/ХТ2024/0021, 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 001/ХТ2024/0053 дугаар тогтоолд шүүгчийг тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмжийг албан тушаалын цалин дээр хуульд заасан бусад нэмэгдлийг нэмж тооцон олгохоор дүгнэсэн.

7.2.Дээрх аргачлалын дагуу Ховд аймаг дахь Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгчээр ажиллаж байсан Г.Сонинболорын авч байсан албан тушаалын үндсэн цалин, онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн дүнг оруулан тооцоход 1 сарын дундаж цалин 3,870,850.83 мөнгө гарч байгаа бөгөөд үүнийг 36 сарын хугацаагаар тооцоход 139,350,630 төгрөгийг тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжид олгохоор тооцоо гарсан байх тул Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 128/ШШ2024/0041 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 221/МА2024/150 дугаар магадлалыг үндэслэн 38,550,627 төгрөг олгож, нэхэмжлэгч Г.Сонинболорт нийт



139,350,630 төгрөг буюу тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмжийг бүрэн олгоод байна.

7.3.Иймд давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь дээр дурдсан үндэслэл, дүгнэлтийн дагуу хуульд нийцээгүй, хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн, хууль ёсны байх зарчимд нийцээгүй байх тул гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн магадлалыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

8.Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 344 дүгээр тогтоолоор хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Чулуунчимэгийн хяналтын журмаар гаргасан гомдлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3-т заасан үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

#### ХЯНАВАЛ:

9.Анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэв.

Тогтоогдсон үйл баримтын тухайд:

10.Нэхэмжлэгч Г.Сонинболор нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 69 дүгээр зарлигаар шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгджээ.

11.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9-д заасан шүүгчийн өндөр насны тэтгэврийн нэг удаагийн тэтгэмж болох 100,800,000 төгрөгийг 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр нэхэмжлэгчид шилжүүлсэн бөгөөд нэхэмжлэгч Г.Сонинболор нь дутуу тэтгэмжийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргасан.

12.Шүүхийн ерөнхий зөвлөл Г.Сонинболорын нэхэмжлэлтэй хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх хүрээнд нэхэмжлэгч Г.Сонинболорт 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 38,550,627 төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэхүү хэргийн хувьд хяналтын шатны шүүхээс шийдвэрлэж хариу өгөх шаардлагатай хууль зүйн асуудал нь:

-Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн сарын дундаж цалингийн хэмжээг хэрхэн тооцох тухай байна.

13.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9-д “Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгоно” гэж тусгажээ. Тус зүйлд заасан “дундаж цалин”-ийн бүрэлдэхүүн нь мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т заасан албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, докторын зэргийн, зэрэг дэвийн нэмэгдлээс бүрдэх талаар Ж.Долгормаа ба ШЕЗ, УДШ (Захиргааны хэргийн танхим) 2024.02.19, ХТ-21 тогтоолд тухайлан дүгнэсэн байна.

14.Харин, “дундаж цалин”-г тооцох хугацааны талаар О.Нарангэрэл ба ШЕЗ, УДШ, (Захиргааны хэргийн танхим) 2024.05.06, ХТ-53 тогтоол нь “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам нь энэ тохиолдолд төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ болох бөгөөд уг журмын 2.1-д төрийн албан хаагчийг өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн хэмжээг тогтоохдоо сүүлийн 3 жилийн цалингийн дунджаар сарын дундаж цалин-г тооцохоор тогтоосныг энэ тохиолдолд нөхөн тохируулж хэрэглэнэ” гэж “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг хэрэглэж сүүлийн 3 жилээс цалингийн дунджийг тооцох талаар дүгнэжээ.

15.Давж заалдах шатны шүүх Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.1 дэх заалтын хүрээнд батлагдсан “дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг баримталж дундаж цалин хөлсийг сүүлийн гурван сараас тооцож зөрүүг олгохоор байна гэж дүгнэсэн нь дээрх тогтоолын дүгнэлтээс зөрүүтэй, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсгийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна. Энэ талаар гаргасан хариуцагчийн гомдлыг хүлээн авах үндэслэлтэй.

16.Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно” гэж хуульчилсан бөгөөд шүүгчийн төрийн алба хаахтай холбоотой Монгол Улсын шүүхийн тухай хуульд тухайлан зохицуулаагүй харилцаанд Төрийн албаны тухай хуулийг хэрэглэнэ. Энэ хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын “3 жилийн дундаж”-аар тооцох зохицуулалт нь шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн тэтгэмж олгохтой холбоотой харилцаанд хэрэглэгдэхээр байна.



17.Харин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын агуулга, үйлчлэх хүрээ нь шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах харилцаатай хамааралгүй болох нь журмын 2.3-т зохицуулсан харилцаанаас тодорхой харагдаж байна.

18.Иймд “дундаж цалин”-г сүүлийн гурван сараас тооцох үндэслэлгүй байх тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.4-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 128/ШШ2024/0527 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 221/МА2024/0497 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 47 дугаар зүйлийн 47.9-д заасныг баримтлан нэхэмжлэгч Г.Сонинболорын “Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зөрүү 21,929,373 төгрөгийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргуулах” нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангасугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамж төлөөгүйг дурдсугай.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ**

**Х.БАТСҮРЭН**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.МӨНХТУЯА**

**ШҮҮГЧИД**

**М.БАТСУУРЬ**

**П.СОЁЛ-ЭРДЭНЭ**

**Ц.ЦОГТ**

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН  
ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 11 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 001/ХТ2024/0109

Улаанбаатар  
хот

**Прокурор Н.Эрдэмбилэгийн дүгнэлтээр,  
Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын  
ахлах байцаагчид холбогдох захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн  
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

|                       |                      |
|-----------------------|----------------------|
| Даргалагч, шүүгч:     | М.Батсуурь           |
| Танхимын тэргүүн:     | Д.Мөнхтуяа           |
| Шүүгчид:              | Х.Батсүрэн<br>Ц.Цогт |
| Илтгэгч шүүгч:        | П.Соёл-Эрдэнэ        |
| Нарийн бичгийн дарга: | Б.Зэнээмэдрээ        |

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны  
06 дугаар сарын 25-ны өдрийн 128/ШШ2024/0541 дүгээр шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны  
07 дугаар сарын 23-ны өдрийн 221/МА2024/0478 дугаар магадлалтай,

Хэргийн оролцогчид: прокурор Н.Эрдэмбилэг, хариуцагч  
Н.Өнөрцэцэг нарыг оролцуулан,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт  
шүүгчийн хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 358 дугаар  
хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль  
хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” эсэх гэсэн  
үндэслэлээр прокурорын хяналтын журмаар гаргасан гомдлоор хянан  
хэлэлцэв.

**ТОДОРХОЙЛОХ нь:**

1.Нэхэмжлэлийн шаардлага: Сүхбаатар дүүргийн Улсын  
бүртгэлийн хэлтсийн улсын ахлах байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын  
03-ны өдрийн 0847548 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах





2.Хэргийн нөхцөл байдал: Иргэн П.Хүрэлбаатар нь “иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн” гэх үндэслэлээр иргэний үнэмлэх дахин авах хүсэлт гаргасан байх бөгөөд улсын бүртгэлийн байгууллагаас “Иргэний үнэмлэхийн дүрмийн 2.7.1-д заасан улсын бүртгэлийн тогтоосон журам зөрчсөн” гэж үзэн, зөрчлийн хэрэг үүсгэж, 30000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна. Улмаар энэхүү зөрчлийн хэргийг хянасан прокуророос “зөрчлийн хэрэг биш” гэсэн үндэслэлээр уг шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахаар шүүхэд ханджээ.

3.Прокурор шүүхэд гаргасан дүгнэлтдээ: “... иргэний үнэмлэхийг ашиглаж байгаа иргэн биш, харин хуульд заасан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын иргэний үнэмлэхийг хариуцаж байгаад гэсэн, үрэгдүүлсэн, түүний хүчинтэй байдлыг алдагдуулсан тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Иргэн өөрөө иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн, үрэгдүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь тухайн журамд хамааралгүй, хариуцлага хүлээх үндэслэлгүй” гэж;

4.Хариуцагч улсын бүртгэгчээс “... иргэний үнэмлэх бүртгэлийн дүрмийг хуулийн нэгдсэн сайтад бүртгүүлсэн, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт гэж үзсэн, иргэд иргэний үнэмлэхээ хадгалах эзэмших үүрэгтэй, захиргааны зөрчил мөн” гэж тус тус маргасан.

5.Анхан шатны шүүх дараах үндэслэлээр прокурорын дүгнэлтийг хангахгүй орхиж, шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээсэн. Үүнд:

5.1.Иргэн иргэний үнэмлэхээ өөрөө эзэмших ба иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн нь дүрэмд заасан цэвэр гамтай эзэмших үүргээ зөрчсөн зөрчил болох ба холбогдогч П.Хүрэлбаатар иргэний үнэмлэхээ гээгдүүлснийг “Иргэний бүртгэлийн дүрэм”-ийн 2.7.1-д заасан иргэний үнэмлэх эзэмших, хадгалах үүргээ зөрчсөн гэж үзнэ.

5.2.Иргэний улсын бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн зөрчилд “Иргэний бүртгэлийн дүрэм”-д заасан иргэний үүргээ биелүүлээгүй зөрчил хамаарах юм. Иргэний үүргээ биелүүлээгүй иргэнийг шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй ба бусдын иргэний үнэмлэхийг хадгалж байгаа иргэнд мөн шийтгэл хүлээлгэх талаарх нарийвчлан зохицуулалт байна.

6.Давж заалдах шатны шүүх дараах үндэслэлээр шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Үүнд:

6.1.Иргэний үнэмлэхийг тухайн иргэн өөрөө эзэмшиж, цэвэр гамтай эзэмших, хадгалах үүрэгтэй байх бөгөөд иргэн П.Хүрэлбаатар нь хуульд заасан хадгалах үүргээ биелүүлээгүй байх тул Сүхбаатар дүүргийн

Улсын бүртгэлийн хэлтсийн Улсын ахлах бүртгэгч Б.Өнөрцэцэгийн 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 0847548 дугаартай шийтгэлийн хуудсаар иргэн П.Хүрэлбаатарт "... иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн" гэх үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 4-т зааснаар 30 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 30000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан нь үндэслэлтэй байна.

7.Прокурор Н.Эрдэмбилэг хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

7.1.Иргэний үнэмлэхийн дүрмийн 2.7.1-д "иргэний үнэмлэхийг цэвэр гамтай эзэмших, хадгалах" үүргийг иргэн хүлээх талаар тусгасан нь иргэн өөрийн эзэмшиж байгаа иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн. Үрэгдүүлсэн үед хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан зохицуулалт биш, уг дүрмийн 2.8-2.12 дахь заалтад тухайн иргэн хүний иргэний үнэмлэхийг хадгалж байгаа этгээд гээсэн, үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан тохиолдолд иргэний үнэмлэх эзэмшигчид бус харин хадгалж, хамгаалж байгаа этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар нарийвчлан зохицуулсан зохицуулалтыг оруулж өгсөн.

7.2.Улсын бүртгэлийн баримт бичгийг эзэмших талаарх журмыг чанд сахих үүргийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлд заасан "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй" зөрчилд хамаарч байгаа бөгөөд дээрх төрлийн зөрчлийг цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан шалгаж шийдвэрлэх байтал улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийг буруу хэрэглэж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяаллыг зөрчиж хүнд шийтгэл оногдуулж байгаа нь үндэслэлгүй юм.

7.3.Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "зөрчлийн шинжийг энэ хууль, бусад хууль захиргааны хэм хэмжээний актаас тодорхойлно", мөн зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Энэ хуулийг төсөөтэй хэрэглэхгүй" гэсэн хууль ёсны зарчмыг гажуудуулж байгаа гэж үзэхээр байна.

8.Хариуцагчаас хяналтын журмаар гаргасан гомдолд холбогдуулж бичгээр тайлбар гаргаагүй байна.

#### ХЯНАВАЛ:

9.Хяналтын шатны шүүхээс энэхүү маргааныг цаашид хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтооход зарчмын хувьд ач холбогдолтой гэж үзэж, хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд, шийтгэлийн хуудсыг дараах үндэслэлээр хүчингүй болгож шийдвэрлэлээ.



10.Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 4-т “Иргэний улсын бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр ... торгоно” гэж заасныг маргааны үйл баримтад холбогдуулан хэрэглэхэд “иргэний бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчих” гэдэгт агуулгын болон системчилсэн тайлбар хийж, нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн, албадлагаар хамгаалагдсан хэм хэмжээ мөн эсэхэд эрх зүйн дүгнэлт хийх шаардлагатай юм.

11.Анхан шатны шүүхийн “... иргэний үнэмлэхээ гээгдүүлснийг “Иргэний бүртгэлийн дүрэм”-ийн 2.7.1-д заасан иргэний үнэмлэх эзэмших, хадгалах үүргээ зөрчсөн гэж үзнэ” гэх дүгнэлт, давж заалдах шатны шүүхийн “... Иргэний үнэмлэхийг тухайн иргэн өөрөө эзэмшиж, цэвэр гамтай эзэмших, хадгалах үүрэгтэй байх бөгөөд иргэн П.Хүрэлбаатар нь хуульд заасан хадгалах үүргээ биелүүлээгүй ...” гэх дүгнэлт нь хуулийг буруу тайлбарласан, нийтийн болон хувийн эрх зүйн харилцааг буруу тодорхойлсноос шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй байна.

12.Зөрчлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино” гэж, 2.1 дүгээр зүйлийн 1-д “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ” гэж тус тус заасан, нийгмийн харилцааг зохицуулах эрх зүй нь тодорхой салбарт ангилагдана, тэдгээрийн ерөнхий болон тусгай шинжийг позитив эрх зүйн онолын үүднээс тодорхойлох бөгөөд “зөрчлийн эрх зүй” нь нийтийн эрх зүйд хамааралтай, нийтийн эрх зүйн хүрээнд хариуцлага хүлээлгэх “зөрчил” нь нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан эрх, үүргийг зөрчсөн байх, тухайн зөрчлийн үр дагавар нь нийтийн эрх ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн байх зэрэг эрх зүйн үр дагавар, шинжийг шаардана.

13.Өөрөөр хэлбэл, аливаа хууль, хэм хэмжээний актыг зөрчсөн тохиолдол бүр нь нийтийн эрх зүйн хүрээнд зөрчил үйлдсэнд тооцогдохгүй, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй, нийтийн эрх зүйн харилцааны явцад хууль, хэм хэмжээний актын заалт зөрчигдсөн боловч энэ нь тухайн этгээдэд зөвхөн өөрт нь хамааралтай, эсхүл уг харилцаанд оролцогч талуудад хамааралтай бөгөөд нийтийн эрх зүйн хүрээнд ямар нэг үр дагавар үүсгээгүй бол нийтийн эрх зүйн хүрээнд зөрчил үйлдсэнд тооцохгүй, ийм зөрчилд торгууль шийтгэл хүлээлгэх үндэслэлгүй.

14.Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 396 дугаар тогтоолоор “Монгол Улсын иргэний үнэмлэхийн дүрэм”-ийг баталсан, уг дүрмийн 2.7-д “Иргэн иргэний үнэмлэхээ эзэмшихэд дараах үүрэг хүлээнэ”, 2.7.1-д “иргэний үнэмлэхийг цэвэр гамтай эзэмших, хадгалах” гэж заасныг маргааны үйл баримтад хамааруулан тайлбарлахад, иргэний үнэмлэхээ цэвэр, гамтай эзэмшээгүй, хадгалаагүй эсхүл хаяж үрэгдүүлсэн нь нийтийн эрх зүйн хүрээний зөрчилд тооцогдохгүй, учир нь иргэн өөрийн иргэний үнэмлэхээ гамгүй эзэмшсэн эсхүл гэсэн нь нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн үр дагавар үүсгэхгүй, нийтээр тогтоосон журам, зан заншлын хэм хэмжээнд сөргөөр нөлөөлөхгүй, нийгэмд хор уршиг учруулахгүй, өөр бусад хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй, зөвхөн хувь иргэнд өөрт нь эрх зүйн үр дагавар үүсэх боломжтой байх тул улсын бүртгэлийн байгууллага тухайн иргэнийг зөрчил үйлдсэнд тооцож Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэж шийтгэл оногдуулсан нь буруу байна.

15.Түүнчлэн, Монгол Улсын иргэний үнэмлэхийн дүрмийн 2.5-д “Иргэн иргэний үнэмлэхээ гэсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд тухайн иргэний биечлэн гаргасан өргөдөл, эсхүл 18 насанд хүрээгүй хүний иргэний үнэмлэхийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагын төлөөлөгчийн өргөдөл, хяналтын улсын байцаагчийн шийдвэрт үндэслэн иргэний үнэмлэх дахин олгоно” гэж заасан байхад хариуцагч улсын бүртгэлийн байгууллагаас зөрчлийн хэрэг үүсгэж, торгууль 30000 төгрөг төлөхийг шаардаж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй.

16.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8-д “Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл прокурор дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ” гэж заасан байх тул захиргааны хэргийн шүүхээс прокурорын дүгнэлтээр захиргааны хэрэг үүсгэж, маргааныг хянан шийдвэрлэсэн нь хуулийн зөрчилгүй, прокурор нь захиргааны хэргийн шүүхэд хандаж, дүгнэлт бичих эрхтэй байх бөгөөд прокурорын “... иргэн өөрийн эзэмшиж байгаа иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн, үрэгдүүлсэн үед хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан зохицуулалт биш” гэх гомдол үндэслэлтэй.

17.Дээрх үндэслэлүүдээр шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 0847548 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.



18.Хариуцагч улсын бүртгэлийн байгууллага нь иргэний үнэмлэхээ хаясан, үрэгдүүлсэн, гэсэн тохиолдол бүрд иргэнийг торгож, торгуулиа төлсний дараа иргэний үнэмлэх шинээр олгох нь хуулийг буруу хэрэгжүүлж байгаа үйлдэл мөн бөгөөд шүүхийн энэхүү шийдвэр нь нэгэнт төлөгдсөн торгуульд хамаарахгүй, төлсөн торгуулиа буцаан шаардах эрхийг иргэнд үүсгэхгүй, харин шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойших үйл баримтад хамаарч, хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоох үр дагавартай болохыг дурдах нь зүйтэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.4-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 128/ШШ2024/0541 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 221/МА2024/0478 дугаар магадлалыг хүчингүй болгож, Зөрчлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1, 2.1 дүгээр зүйлийн 1, 15.24 дүгээр зүйлийн 4-т заасныг тус тус баримтлан прокурор Н.Эрдэмбилэгийн гомдлыг хангаж, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 0847548 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар хариуцагчаас тэмдэгтийн хураамж төлөөгүйг дурдсугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ**

**М.БАТСУУРЬ**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.МӨНХТУЯА**

**ШҮҮГЧИД**

**Х.БАТСҮРЭН**

**Ц.ЦОГТ**

**П.СОЁЛ-ЭРДЭНЭ**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 11 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 001/ХТ2024/0117

Улаанбаатар  
хот

### **“Ондо” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Харилцаа холбооны зохицуулах хороонд холбогдох захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн захиргааны хэргийг давж заалдах  
журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч: П.Соёл-Эрдэнэ

Шүүгчид: Д.Батбаатар

Ц.Цогт

Х.Эрдэнэсүвд

Илтгэгч шүүгч Г.Банзрагч

Нарийн бичгийн дарга: Б.Зэнээмэдрээ

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 08  
дугаар сарын 02-ны өдрийн 221/ШШ2024/0028 дугаар шийдвэртэй хэргийг,

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Оргилмаагийн давж  
заалдах гомдлоор, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Одмаа,  
Г.Оргилмаа, өмгөөлөгч Н.Наранбаяр, хариуцагчийн итгэмжлэгдсэн  
төлөөлөгч З.Амгалан, Т.Мөнхнаран, А.Болортуяа, С.Янжиндулам,  
өмгөөлөгч Б.Цэнгэл, гуравдагч этгээд “Скайтел” ХХК-ийн итгэмжлэгдсэн  
төлөөлөгч Ч.Дэлгэрдаваа, Ө.Жамбалсүрэн, гуравдагч этгээд “Юнител”  
ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Анхбаяр, өмгөөлөгч Н.Энхчимэг,  
гуравдагч этгээд “Мобиком корпораци” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч  
Ч.Буянтогтох, өмгөөлөгч Э.Энх-Эрдэнэ нарыг оролцуулан хянан хэлэлцэв.

### ТОДОРХОЙЛОХ нь:

#### 1.Нэхэмжлэлийн шаардлага:

Нэхэмжлэгч “Ондо” ХХК нь Харилцаа холбооны зохицуулах  
хороонд холбогдуулан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны  
09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан  
“Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн



зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын 4.5-д "Үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтын дагуу технологиос үл хамаарах зарчмыг баримтлан хүснэгт 2-т үзүүлсэн радио давтамжийн зурвасыг 4G, 5G сүлжээнд хэсэгчлэн болон бүрэн зурвасаар шилжүүлэн ажиллуулах тохиолдолд Зохицуулах хороонд хүсэлт гаргаж Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль журмын дагуу оруулж ашиглана" гэж заасныг хүчингүй болгуулах" шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагаа "Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын 4.3-ын хүснэгт 2, 4.8-ын хүснэгт 3-ыг хүчингүй болгуулах" гэж нэмэгдүүлжээ.

## 2.Хэргийн нөхцөл байдал:

2.1.Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралтаар "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг баталсан байна.

## 3.Нэхэмжлэгчээс дараах үндэслэлээр маргаж байна. Үүнд:

3.1."... Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын 4.5 дахь заалтад радио давтамжийн зурвасыг 4G, 5G сүлжээнд "шилжүүлэн" ажиллуулах тухай заасан. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.8, Радио долгионы тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 11 дүгээр зүйлийн 11.6.2-т заасан зохицуулалтаас харахад радио давтамжийн зурвасыг 4G, 5G сүлжээнд "шилжүүлэн" ажиллуулах нь агуулгын хувьд радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйлдэл болж байна. Зөвшөөрлийн тухай хуульд сонгон шалгаруулалтаар олгохоор заасан тусгай зөвшөөрөл болон тус Хуваарилалтын хүснэгтэд сонгон шалгаруулалтаар олгохоор заасан радио давтамжийн зурвасыг маргаан бүхий заалтаар сонгон шалгаруулалтгүйгээр шилжүүлэх замаар олгохоор зохицуулсан нь хууль зөрчсөн. Өмнөх үеийн технологид ашиглагдаж байх үед үүссэн давтамжийн тэгш бус, шударга бус хуваарилалтын тогтолцоо дараа үеийн технологид шилжихэд хадгалагдан үлдэж шударга бус өрсөлдөөнийг үргэлжлүүлэх нөхцөлийг маргаан бүхий заалт бий болгосон.

3.2.Цахим хөгжил, харилцаа холбооны яам Үндэсний хүснэгт батлан мөрдүүлсний үндсэн дээр сонгон шалгаруулалтын журмаар радио давтамж хуваарилагдахаар байтал, Зохицуулах хороо нь маргаан бүхий заалт оруулан журмыг баталж зах зээлд давамгай байдалтай, хамгийн

их давтамж эзэмшиж байгаа аж ахуйн нэгж сонгон шалгаруулалтгүйгээр өөрийн давтамжаа дараа үед ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн. Түүнчлэн, тусгай зөвшөөрлөөр олгогдсон радио давтамжийн зурвасыг шилжүүлэн ашиглахыг зөвшөөрсөн хуулийн ямар ч зохицуулалт байхгүй.

3.3.Мөн 4.3 дахь заалтын Хүснэгт 2, 4.8 дахь заалтын Хүснэгт 3 нь төлөвлөлт, хуваарилалтын агуулгатай нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ буюу “журам” байна. Зохицуулах хороо нь Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.2</sup>-т заасны дагуу радио давтамж, радио давтамжийн зурвасын “хуваарилалт хийх” буюу яамны хуваарилсан журамд нийцүүлэн тусгай зөвшөөрөл олгох чиг үүрэгтэй. Гэтэл маргаан бүхий журмыг батлах замаар өөрт олгогдоогүй эрх мэдлийг хэрэгжүүлсэн нь хууль бус байна. ... “Ондо” ХХК нь үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор давтамж зурвас авахаар удаа дараа хүсэлт гаргасан хэдий ч олгохоос татгалзсан. Энэ нь Зохицуулах хороо радио давтамжийг субъектив байдлаар төлөвлөж, үр ашиггүй хуваарилалт хийсэнтэй шууд холбоотой төдийгүй давтамж олгодог байгууллага нь төлөвлөж, хуваарилалт хийх замаар давамгай байдалтай аж ахуйн нэгжүүдэд илүү их хэмжээний давтамж олгосон байна. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж өгнө үү” гэж маргажээ.

4.Хариуцагчаас нэхэмжлэлийн шаардлагыг дараах үндэслэлээр эс зөвшөөрсөн. Үүнд:

4.1.“... Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.2</sup>, 5<sup>1.1.8</sup>-д заасан бүрэн эрхийн хүрээнд Зохицуулах хороо нь төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Бодлогын чиглэл, Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тус тус үндэслэн “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан. Нэхэмжлэлийн шаардлагад дурдсан маргаан бүхий 4.5 дахь заалт нь бодлогын чиглэлийн дагуу оператор компаниуд нь өмнөх үеийн хөдөлгөөнт холбоо буюу 2G, 3G-д одоо ашиглаж буй радио давтамжаа уг тусгай зөвшөөрлийнхөө хүчинтэй хугацаандаа дараа үеийн хөдөлгөөнт холбоо буюу 4G, 5G сүлжээнд шилжүүлэн ашиглах боломжтойг сануулсан заалт тул нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөөгүйгээс гадна, радио давтамжийн эрэлт хэрэгцээ, үр ашгийг нэмэгдүүлэх, радио давтамжийн бодлогын заалт тул 4.5 дахь заалтыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү.

4.2.Мөн нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлагын хувьд, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.2</sup>-т зааснаар Зохицуулах хороо нь дараа үеийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамж, радио давтамжийн зурвасыг салган авч, зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг тодорхойлж баталдаг. Хуулиар олгосон эрхийнхээ хүрээнд радио давтамжийн зурвас/сүлжийн хуваарилалтыг хийж байгаа тул хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.





5.Гуравдагч этгээд “Скайтел” ХХК-аас нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “... Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1-д заасны дагуу радио давтамжийн тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгох зохицуулалт нь Зөвшөөрлийн тухай хууль батлагдахаас өмнө олгогдсон, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаагүй, тусгай зөвшөөрлийн хувьд хүчинтэй байх хугацаанд маргаан бүхий заалтад заасны дагуу шилжүүлэн ашиглах боломжтой. Харин хүчинтэй хугацаа дууссаны дараа сонгон шалгаруулалтын журмаар олгохоор байна. ... Дараа үеийн буюу 5G сүлжээний радио давтамжийн тухайд Харилцаа холбооны зохицуулах хорооноос сонгон шалгаруулалтаар олгохоор зохицуулсан бөгөөд Зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хууль, холбогдох журмаар тусгайлан олгосон эрх хэмжээний хүрээнд маргаан бүхий захиргааны хэм хэмжээний актыг баталсан гэж үздэг. Иймд нэхэмжлэлийн үндсэн болон нэмэгдүүлсэн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэж,

6.Гуравдагч этгээд “Юнител” ХХК-аас нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “... Маргаан бүхий заалт нь аливаа хууль тогтоомж зөрчөөгүй бөгөөд харин ч олон улсын цахилгаан холбооны байгууллага, дэлхийн бусад орнууд, шинэ үйлчилгээ нэвтрүүлэхэд баримталдаг жишгийн дагуу хийгдсэн зохицуулалт юм. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 дугаар тушаалаар үндэсний радио давтамжийн хүснэгтэд тодорхойлсон, одоо эзэмшиж байгаа радио давтамжийн хүчинтэй хугацаа нь дууссаны дараа сонгон шалгаруулалтын журмаар дахин олгохоор болсон. Иймд нэхэмжлэлийн шаардлага нь хууль зүйн үндэслэлгүй байх тул үндсэн болон нэмэгдүүлсэн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй” гэж,

7.Гуравдагч этгээд “Мобиком корпораци” ХХК-аас нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “... Журмын төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос урьдчилан боловсруулж, харилцаа холбооны салбар компаниудад төслийг хүргүүлэн санал авсан бөгөөд нэхэмжлэгч компаниас хамгийн их буюу 35 санал гаргасан тул журмын боловсруулалтад өөрөө оролцсон гэж үзэх үндэслэлтэй. Харилцаа холбооны салбар компаниуд хуулийн шаардлагын дагуу тодорхой хугацаанд ашиглах эрхтэй авсан радио давтамж бүхий тусгай зөвшөөрлүүдээ техник технологийн шинэчлэлийн дагуу сайжруулан ашиглахыг хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй бөгөөд тус харилцааг зохицуулсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.5 дахь заалт холбогдох хуульд нийцсэн. Нэхэмжлэлийн үндсэн болон нэмэгдүүлсэн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй” гэж тус тус маргажээ.

8.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх маргааныг анхан шатны журмаар хэлэлцэж, дараах үндэслэлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна. Үүнд:

8.1.“... Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ын 4.5 дахь заалт нь аливаа хууль, тогтоомжийг зөрчөөгүй. Дээрх хэм хэмжээний актын төслийг Зохицуулах хорооноос урьдчилан боловсруулж, харилцаа холбооны салбар компаниудад төслийг хүргүүлэн санал авсан байх бөгөөд нэхэмжлэгчээс 35 санал гаргаж хүргүүлсний 25 саналыг нь хүлээн авч тусгажээ.

8.2.Мөн дээрх заалтад бодлогын чиглэлийн дагуу оператор компаниуд нь өмнөх үеийн хөдөлгөөнт буюу 2G, 3G-д одоо ашиглаж буй радио давтамжаа уг тусгай зөвшөөрлийнхөө хүчинтэй хугацаандаа дараа үеийн хөдөлгөөнт холбоо буюу 4G, 5G сүлжээнд шилжүүлэн ашиглах боломжтой талаар зохицуулсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон тохиолдолд 5G технологид сонгон шалгаруулалтын журмаар шинээр олгохоор байна. Иймд журмын 4.5 дахь заалт нь нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөөгүй, нэхэмжлэгчид бодитоор сэргэх эрх, хууль ёсны ашиг сонирхол тогтоогдохгүй байна.

8.3.Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.2</sup>-т зааснаас үзэхэд Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио давтамжийн хуваарилалтыг хийх харилцааг зохицуулдаг ба өөрт тусгайлан олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд журмыг баталсан гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, хариуцагчийг “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ыг батлах эрх хэмжээгүй, өөрт олгогдоогүй эрх мэдлийг хэрэгжүүлсэн гэж үзэхгүй...” гэх зэргээр дүгнэсэн байна.

9.Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Оргилмаа давж заалдах журмаар гаргасан гомдолдоо:

9.1.Шүүх нэхэмжлэлийн үндсэн шаардлагыг хэрэгсэхгүй болгохдоо “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.5 дахь заалт “аливаа хууль тогтоомжийг зөрчөөгүй байна гэж үзэхээр байна, нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөөгүй, нэхэмжлэгчид бодитоор сэргэх эрх, хууль ёсны ашиг сонирхол тогтоогдохгүй...” гэж тус тус дүгнэсэн нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий биш, нотлох баримтыг буруу үнэлсэн, хууль буруу хэрэглэсэн.

9.2.Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй тухайд: Харилцаа холбооны зохицуулах хороонд “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг батлах бүрэн эрх байгаа эсэх, тухайн журмыг нийтээр дагаж мөрдөх үүрэгтэй эсэх дээр огт маргаагүй, харин



журмын 4.5 дахь заалт хууль зөрчсөн тул хүчингүй болгуулахыг хүссэн боловч шүүх шийдвэрийнхээ Үндэслэх хэсгийн 3.1, 3.2, 3.3 дахь хэсгүүдэд огт маргаагүй асуудлаар дүгнэлт хийсэн байх ба энэ нь шийдвэртэй хэрхэн уялдах нь ойлгомжгүй, хэрэгт хамааралгүй байна. Түүнчлэн шийдвэрийн Үндэслэх хэсгийн 3.4-т “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.5-д “... гэж заасан нь аливаа хууль, тогтоомжийг зөрчөөгүй гэж үзэхээр байна” гэж шийдвэрийн бусад үндэслэл, агуулгатай огт холбогдоогүй бие даасан дүгнэлт хийжээ. Энэхүү дүгнэлтийг ямар үндэслэлээр, ямар нотлох баримтад тулгуурлан хийснээ тайлбарлаагүй. Нэхэмжлэгчийн тайлбар, үндэслэлүүд хэрхэн үгүйсгэгдэж байгаа талаар няцаалт гаргаагүй нь шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй.

9.3.“Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.5 дахь заалт нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй хүчин төгөлдөр бус хэм хэмжээний актад үндэслэсэн учир хүчингүй. Радио давтамжийн зурвас ашиглах “технологи” нь тусгай зөвшөөрлийн үндсэн нөхцөлд хамаарна. Тиймээс, шинэ үеийн технологид шилжүүлэн ашиглахыг зөвшөөрөх нь тусгай зөвшөөрөл шинээр олгох үйлдэл бөгөөд холбогдох хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох зохицуулалтыг баримтлах ёстой. Хууль, бусад хэм хэмжээний актад дараа үеийн хөдөлгөөнт холбоонд ашиглах радио давтамжийг сонгон шалгаруулалтаар олгохоор заасан байтал сонгон шалгаруулалтгүйгээр дараа үеийн технологид ашиглах хууль бус боломж нээсэн. Хороонд хуульд зааснаас бусад тохиолдолд “Шилжүүлэн ашиглах” зөвшөөрөл олгох эрх олгосон хуулийн ямар ч зохицуулалт байхгүй буюу хуулиар олгогдоогүй эрхийг хууль бусаар өөртөө бий болгосон.

9.4.Нотлох баримт буруу үнэлсэн тухайд: Шийдвэрийн Үндэслэх хэсгийн 3.5-д “... нэхэмжлэгч “Ондо” ХХК-аас 35 санал гаргаж, Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлснээс 25 саналыг нь хүлээн авч тусгажээ” гэж дүгнэсэн. Гэтэл шүүх тус дурдсан 35 саналын 34 нь маргаан бүхий заалттай холбоогүй бөгөөд Зохицуулах хорооны зүгээс хүлээж авсан 25 санал ч мөн хамааралгүй болох үйл баримтыг анхааран үзсэнгүй. Журамтай холбоотой 35 санал гаргасны дотор 4.5 дахь заалтыг бүхэлд нь хасах санал гаргасан ч саналыг огт хүлээж авалгүй журмын төслийг баталсан.

9.5.“... Маргаан бүхий захиргааны хэм хэмжээний акттай холбогдуулан шилжүүлэн ашиглах зохицуулалт, өөрөөр хэлбэл технологиос үл хамаарах энэ зарчмыг баримталсан санал дээр саналаа гаргаж байсан. Гэхдээ боловсруулалтын ажлын хэсэг “энэ бол Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас гаргасан бодлогын чиглэлд маш тодорхой заасан учраас бид нар бодлогын чиглэлээ дагана, төрийн захиргааны төв байгууллагын

бодлогоо дагана гэдэг утгаар баримт бичигтээ хэвээр үлдээж өгсөн ..." гэх тайлбарыг өгсөн. Шүүх нэхэмжлэгчээс гаргасан саналыг хүлээж аваагүй байдлыг харгалзан үзэлгүй, хэрэгт ач холбогдолгүй буюу маргаан бүхий заалттай холбоогүй саналыг Зохицуулах хороо хүлээн авсан талаарх нотлох баримтыг үндэслэсэн нь буруу.

9.6.Хууль буруу хэрэглэсэн тухайд: Шийдвэрийн Үндэслэх хэсгийн 3.6-д "... 4.5-д бодлогын чиглэлийн дагуу оператор компаниуд нь өмнөх үеийн хөдөлгөөнт буюу 2G, 3G-д одоо ашиглаж буй радио давтамжаа уг тусгай зөвшөөрлийнхөө хүчинтэй хугацаандаа дараа үеийн хөдөлгөөнт холбоо буюу 4G, 5G сүлжээнд шилжүүлэн ашиглах боломжтой талаар зохицуулсан байх ба тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон тохиолдолд 5G технологид сонгон шалгаруулалтын журмаар шинээр олгохоор байна" гэж дүгнэсэн нь үндэслэлгүй.

9.7.Зөвшөөрлийн тухай хууль болон Радио долгионы тухай хууль, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 дугаар тушаалаар баталсан "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт" ("Үндэсний хүснэгт" гэх)-ийн аль алинд нь 5G технологид ашиглах радио давтамжийг "сонгон шалгаруулалт"-аар олгохоор заасан. Шүүх 2023 оны А/42 дугаар тушаалын 2 дахь заалт нь "... хүчин төгөлдөр эзэмшиж байгаа радио ... давтамжийн зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссаны дараа сонгон шалгаруулалтын журмыг хэрэгжүүлсүгэй." гэж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг хамгаалсан (захиргааны байгууллагын итгэл хамгаалах зарчмын хүрээнд хүчинтэй хугацаа дуусахаас нь өмнө олгосон тусгай зөвшөөрлийг хөндөхгүй байх ойлголт) зохицуулалтыг сонгон шалгаруулалтгүйгээр 5G технологид ашиглах эрх олгосон (өмнөх үеийн технологид ашиглахаар радио давтамжийн тусгай зөвшөөрөл авсан этгээдэд) заалт мэтээр буруу дүгнэжээ. Дээр дурдсанаар хуульд 5G технологид ашиглах радио давтамжийг сонгон шалгаруулалтаар олгохоор заасан байхад хэм хэмжээний актаар түүнтэй шууд зөрчилдсөн, үгүйсгэсэн буюу сонгон шалгаруулалтгүйгээр 5G технологид ашиглахаар зохицуулж байгааг шүүх анхаарсангүй.

9.8.Ашиг сонирхол хөндөгдсөн эсэх талаар буруу дүгнэсэн тухайд: Шийдвэрийн Үндэслэх хэсгийн 3.7-д "Иймд ... 4.5 дахь заалт нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөөгүй, нэхэмжлэгчид бодитоор сэргэх эрх, хууль ёсны ашиг сонирхол тогтоогдохгүй ..." гэж дүгнэсэн. Дээр тайлбарласанчлан дурдсан үндэслэлүүд нь буруу байхад шүүх нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдөөгүй гэж дүгнэсэн нь шударга бус. Түүнчлэн, нэхэмжлэгч харилцаа холбооны тэр дундаа радио долгионы тусгай зөвшөөрөл эзэмшигчийнхээ хувиар маргаан бүхий журмын үйлчлэл шууд чиглэсэн, түүний зохицуулалтад өртөж байгаа этгээд юм. Радио давтамж нь хязгаартай нөөц бөгөөд салбарын технологийн дэвшил, хөгжил, шударга өрсөлдөөнийг дэмжих зөв балансыг барих үүднээс зохицуулах байгууллага болох Зохицуулах хороо



үйл ажиллагаа явуулж, зохицуулалт хийдэг. “Ондо” ХХК нь тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа таван байгууллагын нэг, өрсөлдөгчийн хувиар тус салбарын хязгаартай нөөцийн хуваарилалт шударга бус бөгөөд буруу хийгдэхэд шударгаар өрсөлдөх эрх нь хөндөгдөж, бизнесийн өсөлт, хөгжилд нь шууд нөлөөлдөг.

9.9.Журмын 4.5 дахь заалт хүчинтэй үйлчилснээр 5G технологийн өрсөлдөөнд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа этгээдүүд тэгш бус гараанаас оролцох нь гарцаагүй. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчээс 4 дахин их давтамжтай компани зарим давтамж дээрээ өмнөх үеийн технологиор үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ, бусад давтамж дээрээ дараа үеийн 5G технологи дээрээ үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн төлбөрийн болон бусад аливаа нэмэлт үүрэг, саад бэрхшээлийг (сонгон шалгаруулалт байхгүй учраас) туулахгүйгээр үйлчилгээ үзүүлэх боломж нээгдэнэ. Тэр хооронд цөөхөн давтамжтай нэхэмжлэгчийн хувьд дараа үеийн 5G технологи руу орохын тулд сонгон шалгаруулалт зарлахыг хүлээх, зарлагдсан хугацаанд нь нэмэлт төлбөрийн болон бусад үүрэг, саад бэрхшээлийг туулан байж орно. Энэ бол 5G технологийн өрсөлдөөнд талуудад тэгш бус, шударга бус гарааг тулгаж буй хууль бус үйлдэл юм.

9.10.Харин дээрх заалт хүчингүй болсноор давтамжийн тэгш бус, хэт ялгамжтай хуваарилалт бүхий хүндрэлтэй орчинд үйл ажиллагаа явуулж байгаа нэхэмжлэгчийн шударгаар өрсөлдөх, үйлчлүүлэгчдэдээ чанартай, хүртээмжтэй, өндөр технологийн үйлчилгээ үзүүлэх, бизнесээ шударгаар эрхлэх боломжоор хангагдах эрх ашиг сэргэж, улмаар 5G технологийг нэвтрүүлэх тэгш боломжоор хангагдана. Иймд нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдөөгүй, сэргэх эрх, ашиг сонирхол байхгүй гэсэн шүүхийн дүгнэлт илт үндэслэлгүй.

9.11.Нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлагын хүрээнд, шүүх нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлагыг хэрэгсэхгүй болгохдоо “... Зохицуулах хороо нь радио давтамжийн хуваарилалтыг хийх харилцааг зохицуулдаг ба өөрт тусгайлан олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд дээрх журмыг баталсан гэж үзэхээр байна” гэж дүгнэн шийдвэрлэсэн нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий биш, нотлох баримт буруу үнэлсэн, хууль буруу хэрэглэсэн.

9.12.Нотлох баримт буруу үнэлсэн тухайд: “Журмын 4.3-ын Хүснэгт 2-т тодорхойлсон дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалтыг хийхдээ “Олон улсын хөдөлгөөнт холбооны стандартчиллын 3GPP байгууллагаас баталсан радио давтамжийн зурвасын хуваарилалт”-ыг мөрдөх, мөн 4.9-д “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглагдах Хүснэгт 2, 3-т үзүүлсэн радио давтамжийн зурвасуудыг 3GPP байгууллагаас баталсан суваг үүсгэх зурвасыг өргөнөөр хуваарилна” гэж тус тус заасан ба уг 3GPP байгууллагаас баталсан баримт бичиг нь хавтаст хэрэгт авагдсан.

Зохицуулах хороо маргаан бүхий хүснэгтээр радио давтамжийн зурвасыг хуваарилахдаа 3GPP байгууллагаас баталсан баримт бичигт заасан 2х30 хэмжээг зөрчиж 2х15 болгон багасган тайрсан, улмаар Монгол Улсад хуваарилагдаагүй N15 ангиллын давтамжийг нэмж оруулан баталсан нь хууль болсон байхад энэ нотлох баримтыг шүүх шийдвэр гаргахдаа үнэлээгүй.

9.13.Хэрэгт авагдсан нотлох баримтаас харахад нам давтамж буюу 800 орчмын давтамж дээр нэхэмжлэгчээс удаа дараа хүсэлт гаргасан боловч нэмж олгоогүй, зөвхөн 2х5 хэмжээгээр олгосон. 2х5 хэмжээ нь хэт бага бөгөөд үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа юм. Дээр дурдсанчлан Зохицуулах хороо 3GPP байгууллагаас баталсан баримт бичгийг зөрчиж давтамжийн төлөвлөлт хийснээр давтамжийг үр ашигтай хуваарилах зарчим алдагдаж, нам давтамж байхгүй байгууллагыг хохироож байна. Нам давтамж нь зузаан бетон ханыг нэвтлэх, доод давхрууд, лифт гэх мэт газарт сүлжээ тасрахгүй байлгах боломж олгодог бөгөөд нэхэмжлэгч үйлчилгээ үзүүлэх цар хүрээний нам давтамжгүйн улмаас үйлчилгээнийх нь чанар өрсөлдөгч байгууллагатай харьцуулахад дор, хүндрэлтэй байгаа. Харин шүүх дурдагдсан нотлох баримтууд, тайлбарыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой эсэх талаар огт дүгнэлт өгөлгүйгээр, орхигдуулан шийдвэр гаргасан нь нотлох баримтыг бодитойгоор үнэлэх хуулийн шаардлагад нийцээгүй.

9.14.Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй тухайд: Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т зааснаар радио давтамжийн зурвасыг төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах журам батлах бүрэн эрх нь зөвхөн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд, харин Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т зааснаар “Радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх” эрхийг Зохицуулах хороонд олгожээ. Өөрөөр хэлбэл, холбогдох хуульд заасан төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах гэсэн тусдаа ойлголт байхад тэдгээрийн ялгаа заагт шүүхээс дүгнэлт өгөөгүй орхигдуулсан. Зохицуулах хороо нь яамны баталсан төлөвлөгөөний дагуу хуваарилалт хийх юм. Гэтэл яам төлөвлөгөө батлаагүй байхад Зохицуулах хороо төлөвлөлтийн шинжтэй хүснэгт баталсан нь эрх мэдлээ хэтрүүлсэн болохыг харгалзан үзсэнгүй. Мөн Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3, 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.2-т заасан Яам болон Зохицуулах хорооны эрх, түүний хүрээ хязгаарыг хуульд үндэслэх замаар бүх талаас нь үнэлсний үндсэн дээр шийдвэр гаргах байсан боловч энэ талаар огт дүгнэлт хийгээгүй нь шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй. Иймд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж өгнө үү ...” гэжээ.

10.Шүүх хуралдаанд хариуцагч болон гуравдагч этгээд нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч болон өмгөөлөгч нараас “нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдол үндэслэлгүй, давж заалдах шатны



шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий тул хэвээр үлдээж өгнө үү” гэсэн агуулга бүхий тайлбарыг (амаар болон бичгээр) тус тус өгөв.

#### ХЯНАВАЛ:

11.Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангах үндэслэлтэй.

12.Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.2</sup>-т “радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах ...” бүрэн эрхийн дагуу хариуцагч Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралтаар “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг (цаашид “журам” гэх) баталсан байна. Энэхүү эрх зүйн баримт бичиг нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан захиргааны хэм хэмжээний актын үндсэн шинжийг агуулсан ба энэ талаар талууд маргаагүй.

13.Хариуцагч дээрх журмыг батлах эрхтэй боловч 4.5 дахь хэсэгт “Үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсад ДҮХХ-ны (дараа үеийн хөдөлгөөнт холбооны) системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.7 заалтын дагуу технологиос үл хамаарах зарчмыг баримтлан хүснэгт 2-т үзүүлсэн радио давтамжийн зурвасыг 4G, 5G сүлжээнд хэсэгчлэн болон бүрэн зурвасаар шилжүүлэн ажиллуулах тохиолдолд Зохицуулах хороонд хүсэлт гаргаж Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль, журмын дагуу оруулж ашиглана.” гэж заасан нь эрх зүйн хэм хэмжээнд нийцээгүй, хууль бус болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

14.Радио долгионы тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Тусгай зөвшөөрөлд радио төхөөрөмжийн байршил, хамрах нутаг дэвсгэр, ашиглах радио давтамж, хүчин чадал, технологи, зөвшөөрлийн хугацаа, ашиглалтын зориулалт зэргийг заана”, 10 дугаар зүйлийн 10.1-д “Тусгай зөвшөөрөл авах өргөдөлд Харилцаа холбооны тухай хуулийн 13.2-т заасан баримт бичгээс гадна дараахь баримтыг хавсаргана:”, 10.1.2-т “радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал, газар зүйн байршил, хамрах хүрээ, ашиглах радио давтамжийн зурвас, радио давтамж, технологи”, 11 дүгээр зүйлийн 11.1-д “Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.8, 8.2 дугаар зүйлийн 8.3-т заасан тусгай болон энгийн зөвшөөрөл олгох бөгөөд зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг энэ хуулийн 10.1, 13.3-т заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянана”, мөн зүйлийн 11.4-т “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлсноос гадна ижил радио давтамжийг

нэг нутаг дэвсгэрт ашиглах тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд сонгон шалгаруулах журмаар тусгай зөвшөөрөл олгоно”, 11.6-д “Сонгон шалгаруулалтын үнэлгээнд дараах нөхцөлийг харгалзан үзнэ:” 11.6.2-т “техник, технологийн сонголт, үзүүлэлт”, 11.7-д “Энэ хуулийн 11.6-д заасан нөхцөлийн дагуу үнэлгээ өгч, хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдэд тусгай зөвшөөрөл олгоно” гэж тус тус зааснаас үзвэл радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг олгоход харгалзан үзэх, мөн тусгай зөвшөөрөлд заавал заах нэг нөхцөл нь “технологи” байна.

15.Өөрөөр хэлбэл, “технологи” нь радио давтамжийн зурвас ашиглах гол нөхцөл нь байх тул тусгай зөвшөөрөл олгоно гэдэг нь угтаа радио давтамжийн зурвасыг ашиглах сүлжээний төрөл буюу ашиглагдах технологийн зөвшөөрөл гэж ойлгогдохоор байна. Ийм ч учир нэхэмжлэгч болон гуравдагч этгээд нарын эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд нь радио давтамжийн зурвас бүрт ашиглагдах технологиороо ялгаатай байдаг байна (жишээ нь зөвшөөрлийн дугаар 24320010, радио давтамж 847-852МГц зө:5МГц, технологи 4G гэх мэт).

16.Иймээс маргаан бүхий журмын 4.5 дахь заалтаар радио давтамжийн зурвасыг 4G, 5G сүлжээнд хэсэгчлэн болон бүрэн зурвасаар шилжүүлэн ажиллуулах нь “агуулгын хувьд тусгай зөвшөөрөл олгох үйлдэл” гэсэн нэхэмжлэгчийн тайлбар үндэслэлтэй, учир нь технологио дагаад зурвас ашиглах эрх нь шууд олгогдохоор байна. Технологи өөрчлөгдөхөд хуулийн дагуу “сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл авах ёстой” гэдэг дээр талууд нэг байр суурьтай, гагцхүү “үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаандаа “технологис үл хамаарах зарчим”-ын дагуу дараа үеийн технологид шууд шилжих боломжтой, харин зөвшөөрлийн хугацаа дуусах үед сонгон шалгаруулалт явуулна” гэсэн тайлбарыг хариуцагч болон гуравдагч этгээд нарын зүгээс өгдөг.

17.Гэвч нэгэнт хуулиар тусгай зөвшөөрлөөр олгогдох ёстой эрхийг маргаан бүхий журмын заалтаар “үйлчилгээ эрхлэгч нь 4G, 5G сүлжээнд хэсэгчлэн болон бүрэн зурвасаар шилжүүлэн ажиллуулах тохиолдолд Зохицуулах хороонд хүсэлт гаргаж, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлтийг оруулж ашиглах” боломжтой байхаар заасан нь Радио давтамжийн тухай хуулийн 9-11 дүгээр зүйлд заасан журмыг зөрчсөн, хуульд заагаагүй үндэслэлээр тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг бий болгосон нь хариуцагч өөрт олгогдсон эрхээ хэтрүүлсэн гэж үзэхээр байх тул энэ талаарх нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг (Тодорхойлох хэсгийн 9.1-9.3, 9.6-9.8) хангах үндэслэлтэй.

18.Түүнчлэн, “журмын 4.5 дахь заалт нь 5G технологийн өрсөлдөөнд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа





этгээдүүдэд тэгш бус гарааны нөхцөлийг бий болгосон, тухайлбал түрүүлж эрх авсан үйлчилгээ эрхлэгч нар нь сонгон шалгаруулалтгүйгээр өөрсдийн эзэмшиж буй радио давтамжийн (зарим) зурвастаа 5G технологиор шууд үйлчилгээ үзүүлэх давуу эрхтэй бол цөөхөн давтамжтай нэхэмжлэгчийн хувьд сонгон шалгаруулалт зарлахыг хүлээх, илүү зардал мөнгө гаргах зэрэг сөрөг үр дагавар үүсгэхээр байгаа нь шударга өрсөлдөөнийг хязгаарласан” гэсэн агуулгатай энэ тогтоолын Тодорхойлох хэсгийн 9.8-9.10-т заасан нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдол үндэслэлтэй.

19.Учир нь, хэргийн бусад оролцогчийн зүгээс нэхэмжлэгчийг “үлдэх зурваст өрсөлдөх боломжтой” гэх боловч угаас хязгаарлагдмал нөөц (зурвас)-тэй энэ тохиолдолд бусад үйлчилгээ эрхлэгч нар өөрсдийн зурваст шинэ технологийг шууд шилжүүлэх тохиолдолд үнэн хэрэгтээ нэхэмжлэгчид өрсөлдөх буюу үлдэх “зах зээл” алга байна. Иймээс маргаан бүхий журмын заалт нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-д заасны дагуу Зохицуулах хороо нь “харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэнтэй зөрчилдөж байна.

20.Дээрх үндэслэлээр Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.5.“Үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсад ДҮХХ-ны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.7 заалтын дагуу технологиос үл хамаарах зарчмыг баримтлан хүснэгт 2-т үзүүлсэн радио давтамжийн зурвасыг 4G, 5G сүлжээнд хэсэгчлэн болон бүрэн зурвасаар шилжүүлэн ажиллуулах тохиолдолд Зохицуулах хороонд хүсэлт гаргаж Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль журмын дагуу оруулж ашиглана” гэсэн заалт нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1.“Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх”, 60.1.2.“тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх” гэсэн захиргааны хэм хэмжээний актад тавигдах эрх зүйн шаардлагыг зөрчсөн тул хууль бус, үүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байна. Иймд нэхэмжлэлийн холбогдох шаардлагыг хангах нь зүйтэй.

21.Гэтэл давж заалдах шатны шүүх “... маргаан бүхий журмын 4.5 дахь заалт нь аливаа хууль, тогтоомжийг зөрчөөгүй, бодлогын чиглэлийн дагуу оператор компаниуд нь өмнөх үеийн хөдөлгөөнт буюу 2G, 3G-д одоо ашиглаж буй радио давтамжаа уг тусгай зөвшөөрлийнхөө хүчинтэй хугацаандаа дараа үеийн хөдөлгөөнт холбоо буюу 4G, 5G сүлжээнд шилжүүлэн ашиглах боломжтой талаар зохицуулсан, тусгай зөвшөөрлийн

хүчинтэй хугацаа дуусгавар болсон тохиолдолд 5G технологид сонгон шалгаруулалтын журмаар шинээр олгохоор байх тул энэ нь нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөөгүй, нэхэмжлэгчид бодитоор сэргэх эрх, хууль ёсны ашиг сонирхол тогтоогдохгүй байна ...” гэх зэргээр хэргийн үйл баримтыг буруу дүгнэн, хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүйгээс шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй байна.

22.Хэдийгээр хариуцагч болон гуравдагч этгээд нарын зүгээс “уг заалт нь төрийн захиргааны төв байгууллагаас баталсан бодлогын чиглэлд тусгагдсан зарчмыг хэрэгжүүлсэн агуулгатай, тухайн шийдвэр хүчин төгөлдөр байгаа тул хууль зөрчөөгүй” гэж тайлбарлах ч, төрийн бодлогын баримт бичиг (чиглэл) нь маргаан бүхий журмын заалт хууль ёсны эсэхийг хянах эрх зүйн шалгуур биш, учир нь захиргааны хэм хэмжээний акт хууль ёсны эсэхийг хянах үндэслэл нь зөвхөн хууль юм.

23.Гуравдагч этгээд нарын “үйлчилгээ эрхлэгчид нь тусгай зөвшөөрлийн хугацаандаа үйл ажиллагаа явуулах эрхтэй, уг эрхийг хугацаанаас нь өмнө цуцлах боломжгүй, Зохицуулах хороо нь зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор холбогдох арга хэмжээ авах үүргийг гэрээгээр хүлээдэг” гэх тайлбарын тухайд, тэд өөрсдийн тусгай зөвшөөрлийн нөхцөлийн дагуу зөвшөөрөгдсөн зурваст, зөвшөөрөгдсөн технологийг ашиглан, зөвшөөрлийн хугацаагаа дуустал үйл ажиллагаагаа явуулах бүрэн боломжтой, иймд дээрх журмын заалтыг хүчингүй болгосон тохиолдолд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөнө гэх үндэслэлгүй. Тодруулбал, гуравдагч этгээд нарт тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаандаа зөвшөөрөлд заасан технологийг өөрчлөхийг буюу дараа үеийн технологид шууд шилжихийг “шаардах эрх” хуулиар олгогдоогүй байна.

24.Нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлага болох “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.3-ын хүснэгт 2, 4.8-ын хүснэгт 3-ыг хүчингүй болгох үндэслэлгүй байна.

25.Учир нь, Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т “радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах ...” болон 5.2.6-д заасан “үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах, хүснэгтэд сонгон шалгаруулалтаар олгох радио давтамжийн зурвасыг тодорхойлох” бүрэн эрхийнхээ хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/42 дугаар тушаалаар “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг баталсан байх ба уг хүснэгтийн 1 дэх баганад Дэлхийн радио холбооны дүрмээр тодорхойлсон 42 төрлийн



радио холбооны үйлчилгээнд хуваарилсан 8.3 кГц-1000 ГГц-ийн хоорондох радио давтамжийн зурвас, 2-т.Радио давтамжин зурвасыг радио холбооны үйлчилгээний төрөлд хуваарилсан ОУЦХБ-ын радио давтамжийн 1-р бүсийн хуваарилалт, 3-т.1-р бүсийн хуваарилалтад үндэслэн радио давтамжийн зурвасыг радио холбооны үйлчилгээний төрөлд хуваасан Монгол Улсын үндэсний хуваарилалт, 4-т.Үндэсний хуваарилалтын дагуу ашиглах радио холбооны үйлчилгээний төлөвлөлт, ашиглалтын зориулалт, 5 дахь баганад радио давтамж олгох тусгай нөхцөлийг тусгажээ.

26.Дээрх хуваарилалтын дагуу хариуцагч Харилцаа холбооны зохицуулах хороо нь Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг баталсан ба үүний 4.3-ын хүснэгт 2-т.ДҮХХ-ны системийн радио давтамжийн хуваарилалтыг, 4.8-ын хүснэгт 3-т.ДҮХХ-ны системийн радио давтамжийн зурвасын хамрах хүрээг тодорхойлсныг “ям төлөвлөгөө батлаагүй байхад Зохицуулах хороо төлөвлөлтийн шинжтэй хүснэгт баталж, эрх мэдлээ хэтрүүлсэн” гэж үзэхгүй, энэ талаарх давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй.

27.Түүнчлэн, журамд “Хүснэгт 2, 3-т үзүүлсэн радио давтамжийн зурвасуудыг 3GPP байгууллагаас баталсан суваг үүсгэх зурвасын өргөнөөр хуваарилна” гэж заасан атлаа хариуцагч маргаан бүхий хүснэгтээр радио давтамжийн зурвасыг хуваарилахдаа 3GPP байгууллагаас баталсан баримт бичигт заасан 2х30 хэмжээг зөрчиж 2х15 болгон багасган тайрсан, улмаар Монгол Улсад хуваарилагдаагүй N15 ангиллын давтамжийг нэмж оруулан баталсан нь хууль бус” гэх нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдол хариуцагчийн тайлбараар няцаагдаж байх бөгөөд маргаан бүхий хүснэгтүүд нь хууль зөрчсөн гэх үндэслэл байхгүй, нэгэнт хууль ёсны тул нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэхгүй юм. Иймд энэ тогтоолын Тодорхойлох хэсгийн 9.11-9.14-т заасан нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлыг хангах боломжгүй байна.

28.Дээрх үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулахаар тогтов.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 221/ШШ2024/0028 дугаар шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6, Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3, 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.2, 9 дүгээр зүйлийн 9.2, 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр

зүйлийн 11.1, 11.6.2, 11.7-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “Ондо” ХХК-аас Харилцаа холбооны зохицуулах хороонд холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.5-д “Үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.7 заалтын дагуу технологиос үл хамаарах зарчмыг баримтлан хүснэгт 2-т үзүүлсэн радио давтамжийн зурвасыг 4G, 5G сүлжээнд хэсэгчлэн болон бүрэн зурвасаар шилжүүлэн ажиллуулах тохиолдолд Зохицуулах хороонд хүсэлт гаргаж Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль, журмын дагуу оруулж ашиглана.” гэж заасныг хүчингүй болгож, нэхэмжлэлийн үлдэх “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.3-ын хүснэгт 2, 4.8-ын хүснэгт 3-ыг хүчингүй болгуулах” шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.” гэж өөрчилж, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангасугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

**ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ**

**ШҮҮГЧИД**

**П.СОЁЛ-ЭРДЭНЭ**

**Д.БАТБААТАР**

**Ц.ЦОГТ**

**Х.ЭРДЭНЭСУВД**

**Г.БАНЗРАГЧ**



**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2.75

**Индекс: 200003**